

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12-р сарын 20-ны өдөр

Дугаар 05/21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйл, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 05/21 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 244454 санал буюу ердийн олонхийн 81,8%-ийн саналаар Компанийн хувьцааг нэгтгэхийг, 244396 санал буюу ердийн олонхийн 81,8%-ийн саналаар Компанийн хувьцааг нэгтгэх журмыг, 244396 санал буюу ердийн олонхийн 81,8%-ийн саналаар Компанийн хувьцааг нэгтгэсэн өөрчлөлтийг компанийн дүрэмд өөрчлөлт оруулахыг тус тус баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ТУЗ-д ажлаа дүгнүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Б.Цолмон

Э.Тогосмаа

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12-р сарын 20-ны өдөр

Дугаар 07/21

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт
оруулах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн тавин ширхэг хувьцааг нэг ширхэг хувьцаа болгон хөрвүүлэх замаар компанийн хувьцааг нэгтгэсэнтэй холбогдуулан компанийн дүрмийн дараах заалтуудыг дор дурьдсан байдлаар өөрчилсүгэй. Үүнд:
“3.1 компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 5000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6268 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
3.2 Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэнд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 5000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6268 ширхэг энгийн хувьцаатай байна”
2. Компанийн дүрмийн өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж бүртгүүлэх, Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсний дараа Улсын бүртгэлийн албанд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-т үүрэг болгосугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Б.Цолмон

Э.Тогосмаа

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН
ТОГТООЛ

2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 05/21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн болон
хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, 4 дэх заалт, 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 298881 ширхэг хувьцаа эзэмшдэг 10 хувьцаа эзэмшигч биеэр оролцож байгаа, 0 хувьцаа эзэмшдэг 0 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа ирүүлсэн нь нийт гаргасан энгийн хувьцааны 85,2 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.4 дэх хэсгийн заалт болон компанийн дүрмийн 6.10 дахь заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 85,2 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА
ГИШҮҮН
ГИШҮҮН



Э.ТОГОСМАА
С.ДЭНСМАА
Д.ДАВААСҮРЭН